



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.9.12 дахь заалт, 48.10 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. "Монголын Хуульчдын холбооны "Судалгааны ажлын журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



П.ОДГЭРЭЛ

Монголын Хуульчдын холбооны
эвлэлийн 2023 оны 23 дугаар сарын 25
ны өдрийн хурлын 04 дугаар тогтоолын
... дугаар хавсралт

8119414

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

1. Энэ журмаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, бусад хууль тогтоомж, Монголын Хуульчдын холбооны дүрэм, стратегийн баримт бичгийг үндэслэн Монголын Хуульчдын холбоо /цаашид "Холбоо" гэх/-ноос судалгааны ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үр дүнг хэлэлцүүлэх, сурталчлах, практикт нэвтрүүлэх, тэдгээртэй холбогдон гарах харилцааг зохицуулна.

2. Судалгааны ажлыг Холбооны Тамгын газрын Судалгааны төв нь чиг үүргийн болон сайн дурын хороод, хуульчдаар дамжуулан дангаар болон хамтран гүйцэтгэнэ.

3. Холбооноос хэрэгжүүлж буй судалгааны ажилд оролцогч этгээд энэхүү журмыг мөрдөнө.

4. Энэ журмаар тусгайлан зохицуулаагүй асуудлыг Холбооны Тамгын газраас санал боловсруулж, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороогоор хэлэлцүүлж, шийдвэрлэнэ.

5. Хууль тогтоох ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх хэлбэрээр гүйцэтгэх судалгааны ажилд энэ журмаас гадна Холбооны "Хууль тогтоох ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх журам"-ыг баримтална.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗАРЧИМ, ҮНДСЭН ЧИГЛЭЛ,
ТӨРӨЛ, ХЭЛБЭР**

2.1 дүгээр зүйл. Судалгааны ажил гүйцэтгэхэд баримтлах зарчим

1. Судалгааны ажлыг гүйцэтгэхэд нийтийн эрх ашиг, ашиг сонирхлын төлөө, эрдэм шинжилгээний нийтлэг үнэт зүйл, академик эрх чөлөө, судлаачийн ёс зүйг эрхэмлэн үйл ажиллагаандаа шинжлэх ухаанч, бүтээлч, бодитой хандах зарчмыг баримтална.

2. Судалгааны ажлын үр дүн, холбогдох төсөв, санхүүжилт, зарцуулалтын талаарх мэдээлэл нээлттэй, ил тод байх зарчимд үндэслэнэ.

2.2 дугаар зүйл. Судалгааны ажлын үндсэн чиглэл

1. Судалгааны ажлыг дараах үндсэн чиглэлийн хүрээнд явуулна.
 - 1.1. Нийгэмд шударга ёс, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх;
 - 1.2. Нийгэмд тулгамдаж буй асуудалд гарц шийдлийг тодорхойлох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах замаар хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд дэмжлэг үзүүлэх;
 - 1.3. Хууль тогтоогч, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тулгамдсан асуудлыг шийдэх талаар зөвлөмж өгөх;
 - 1.4. Хүчин төгөлдөр хууль тогтоомж, эрх зүйн бусад актын хэрэгжилт болон шүүхийн практикт шинжилгээ хийх замаар хууль хэрэглээний нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх;
 - 1.5. Судалгааны ажилд оролцуулах замаар Холбооны гишүүн хуульчдыг мэргэшүүлэх, ур чадварыг нь сайжруулах;
 - 1.6. Судалгаанд үндэслэн хуульчдын сургалтыг чанаржуулах;
 - 1.7. Салбар хороодын үйл ажиллагааг тухайн эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний хувьд идэвхжүүлэн бэхжүүлэх.
 - 1.8. Эрх зүйн салбарын асуудлаар судалгааг бусад хамаарах (эдийн засаг, технологи, нийгмийн халамж гэх зэрэг) салбарыг харгалзаж, салбар дундын хэлбэрээр хамтарч хэрэгжүүлэх арга зүйг төлөвшүүлж хуульчдын бусад салбарын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх.

2.3 дугаар зүйл. Судалгааны ажлын төрөл

1. Судалгааны ажил дараах төрөлтэй байна.
 - 1.1. хууль зүйн нийтлэг бодлогын асуудлаар судалгаа;
 - 1.2. хуулийн болон захиргааны хэм хэмжээний актын төсөл дагалдах судалгаа;
 - 1.3. шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх судалгаа;
 - 1.4. төрийн захиргааны төв байгууллагуудад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилт, үр нөлөөг судлах, арга зүйн туслалцаа үзүүлэх;
 - 1.5. эрх зүйн харьцуулсан судалгаа хийж, үндэсний хууль тогтоомжийн хөгжил, онцлогийг судлах;
 - 1.6. олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурал, сургалт, форум, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, семинар зохион байгуулах;
 - 1.7. гадаадын ижил төстэй судалгааны байгууллагатай хамтран ажиллах, зочин судлаач солилцох, туршлага судлах, олон улсын хурал, семинарт оролцох ажлыг зохион байгуулах зэрэг болно.

2.4 дүгээр зүйл. Судалгааны ажлын үр дүн

1. Судалгааны ажлын үндсэн чиглэлийн хүрээнд дараах бүтээгдэхүүнийг гаргана. Үүнд:
 - 1.1. судалгааны ажлын тайлан;
 - 1.2. хууль тогтоомж, хэм хэмжээний акт, эрх зүйн бусад баримт бичгийн төсөл;
 - 1.3. дүгнэлт, шүүмж, санал, зөвлөмж;
 - 1.4. практикт нэвтрүүлэх аргачлал, арга зүй, заавар, стандарт;
 - 1.5. эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл;
 - 1.6. эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, семинарын үр дүн;
 - 1.7. мэргэшүүлэх сургалтын магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр, албан бус сургалтын хөтөлбөр;
 - 1.8. ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага, эмхэтгэл;
 - 1.9. бусад.

2.5 дугаар зүйл. Судалгааны төслийн хэлбэр

1. Судалгааны ажлыг төсөл хэлбэрээр хэрэгжүүлж болох бөгөөд судалгааны төслийг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

- 1.1. Өөрийн санаачилгаар хэрэгжүүлэх судалгааны төсөл;
- 1.2. Захиалгат судалгааны төсөл;
- 1.3. Судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх төсөл.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХЭРЭГЖҮҮЛЭХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 дүгээр зүйл. Судалгааны ажлыг төлөвлөх

1. Судалгааны ажлыг Холбоо өөрийн санаачилгаар болон захиалгыг үндэслэн төлөвлөнө.

2. Холбооны судалгааны нэгж болох Судалгааны төв нь судалгааны ажлыг гүйцэтгэхдээ бусад байгууллага, хуульч, эрдэмтэн, судлаачтай хамтрах, эсхүл зохицуулах хэлбэрээр гүйцэтгэхээр төлөвлөнө.

3. Судалгааны төв нь гүйцэтгэх төлөвлөгөөт судалгааны ажлын саналыг Салбар эрх зүйн хороодоос авч нэгтгэн, Тамгын газрын даргад танилцуулан, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороогоор хэлэлцүүлсний үндсэн дээр дараа жилд гүйцэтгэх судалгааны ажлыг Холбооны төлөвлөгөөнд тусгуулна.

4. Холбоо өөрийн санаачилгаар хэрэгжүүлэх судалгааны ажлыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар хэрэгжүүлж болно.

3.2 дугаар зүйл. Судалгааны ажлыг хэрэгжүүлэх, тайлагнах, үр дүнг хэлэлцүүлэх, сурталчлах

1. Судалгааны ажлыг хэрэгжүүлэх, тайлагнах, үр дүнг хэлэлцүүлэх, сурталчлах үйл ажиллагааг Судалгааны төв нь Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо, Салбар эрх зүйн хороодтой хамтран зохион байгуулна.

2. Судалгааны ажлыг гүйцэтгэх аргачлалыг Судалгааны төв боловсруулан, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороогоор хэлэлцүүлнэ.

3. Судалгааны ажил бүрд судалгааны зорилго, зорилт, арга зүй, хамрах хүрээ зэргийг тусгасан удирдамж, төлөвлөгөөг судалгааны ажлыг гүйцэтгэх баг боловсруулж, Судалгааны төвийн эрхлэгчээр батлуулна.

4. Судалгааны багийн ахлагч судалгааны захиалгатай холбогдуулан захиалагчаас тайлбар тодруулга, нэмэлт, мэдээлэл гаргуулан авах, судалгааны багийн гишүүдийн ажлыг хуваарилах, оролцоог хангах, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх ба удирдамж, төлөвлөгөөнд заасны дагуу судалгааны ажилд оролцох, мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлан боловсруулах ажлыг хянах ба судалгааны багийн гишүүдийн оролцооны үнэлгээ, олгох ажлын хөлс, урамшууллын саналыг Судалгааны төвийн эрхлэгчид танилцуулна.

5. Судалгааны багийн судлаач нь судалгааны ажлын удирдамж, төлөвлөгөөнд заасан асуудлаар хайлт хийх, мэдээлэл цуглуулах, боловсруулах,

тухайн асуудлаар дүгнэлт, зөвлөмж бичих, тайлан боловсруулах зэргээр ажиллахаас гадна багаар ажиллах үед судалгааны тайлан нэгтгэх, бодлогын хувилбаруудыг тодорхойлж дүгнэлт гаргах, хэрэгжүүлэх арга механизмын талаар санал, зөвлөмж боловсруулна.

6. Судалгааны төв нь судалгааны ажлыг гүйцэтгэхэд болон хуульчдын мэргэжлийн үйл ажиллагаанд шаардлагатай эрдэм шинжилгээний мэдээллээр шуурхай, хүртээмжтэй хангах зорилгоор Хуульчдын номын санг ажиллуулна. Хуульчдын номын санг хэвлэмэл фонд болон цахим хэлбэрээр ажиллуулах журмыг Зөвлөл батална.

7. Салбар эрх зүйн хороо нь судалгааны ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, судалгааны үр дүнг Судалгааны төвд хүргүүлэх ба тус төв нь судалгааны бүтээгдэхүүнийг зохих шаардлагад нийцсэн, бодитой, төвийг сахисан эсэхэд хяналт тавьж, судалгааны багт арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

8. Судалгааны ажил хэрэгжүүлэхэд мэргэжлийн эксперт, зөвлөх, судлаачдыг гэрээгээр ажиллуулах бол хүсэлтийг Тамгын газрын даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

9. Судалгааны ажлыг гүйцэтгэх аргачлалын дагуу нээлттэй хэлэлцүүлэг, мэтгэлцээн, фокус бүлгийн уулзалт, анкетын санал асуулга, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн экспертүүдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулж болох бөгөөд эдгээр арга хэмжээг зохион байгуулахад бусад хороод, нэгжийн оролцоо болон санхүүгийн дэмжлэгийг зохих журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

10. Судалгааны ажлын явцад Холбооны цахим хуудсаар дамжуулан шаардлагатай асуудлаар олон нийтийн саналыг авч, хэлэлцүүлэг хийж болох ба мөн иргэдээс бичгээр ирүүлсэн судалгааны ажилтай холбогдох саналыг судалгааны явцад ашиглаж болно.

11. Судалгааны ажлыг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагаас албан ёсоор мэдээлэл гаргуулан авах шаардлагатай бол Тамгын газрын даргаар уламжлан шийдвэрлүүлнэ.

12. Судалгааны ажлын үр дүнг гүйцэтгэсэн Салбар эрх зүйн хороо, багийн ахлагч нь Судалгааны төвөөр хянуулан, Холбооны санаачилгаар хийсэн судалгааны ажлын үр дүнг Холбооны удирдлагад танилцуулна, захиалгат судалгааны ажлын үр дүнг захиалагчид хүлээлгэн өгнө.

13. Судалгааны төв судалгааны бүтээгдэхүүнийг цахим болон хэвлэмэл байдлаар зохих журмын дагуу төрөлжүүлэн сан үүсгэж, Хуульчдын номын сангийн фондод хадгалуулна.

14. Судалгааны ажлын үр дүнг тодорхой хүрээнд хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзвэл Салбар эрх зүйн хороо нь Судалгааны төв, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо хамтран зохион байгуулна.

15. Хэлэлцүүлгийн зохион байгуулалтыг Тамгын газар хариуцна.

16. Судалгааны төв судалгааны ажлын явцын болон эцсийн үр дүнг олон нийтэд, эсвэл тодорхой бүлгийн хүрээнд сурталчлах, мэдээлэх хэлбэрээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах ба нөлөөллийн бусад арга хэмжээг Холбооны удирдлагын дэмжлэг, оролцоотойгоор зохион байгуулна.

17. Судалгааны ажлын үр дүнг сургалтын хөтөлбөрийн эх сурвалжид ашиглаж болно.

18. Судалгааны ажлын үр дүнг олон нийтийн болон мэргэжлийн хэвлэлд эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, нийтлэл, ярилцлага хэлбэрээр нийтлүүлж болох ба энэ тохиолдолд байгууллагын нэр, судлаачийн нэр, албан тушаалыг хамтад нь дурдсан байна.

19. Судлаач байгууллагын үйл ажиллагааны тухай, байгууллагын байр суурийг илэрхийлсэн мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд

мэдээлэх тохиолдолд Тамгын газарт мэдэгдэх буюу хамтарч ажиллах ба Тамгын газар зөвшөөрөөгүй бол Холбооны нэрийн өмнөөс албан ёсны байр суурийг илэрхийлсэн аливаа мэдэгдлийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээхийг хориглоно.

20. Судлаач нь хувь хүний үзэл бодлоо хэвлэл, мэдээллийн хэрэгслээр илэрхийлэх бол зөвхөн өөрийн нэрээр хаяглана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАХИАЛГАТ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4 дүгээр зүйл. Захиалгат судалгааны төсөл хэрэгжүүлэх

1. Төрийн болон бусад байгууллагаас Холбооны нэр дээр ирүүлсэн, эсхүл зарласан судалгааны ажил гүйцэтгүүлэх захиалгын саналыг хүлээн авч, захиалгат судалгааны төсөл хэрэгжүүлнэ.

2. Судалгааны ажлын захиалгын саналыг Тамгын газрын Судалгааны төв албан бичгээр хүлээн авч баталгаажуулна. Захиалгат судалгааны төслийн нэгдсэн бүртгэлийг Судалгааны төв хариуцан хөтөлнө.

3. Захиалагч нь хуульч судлаачид шууд хандсан бөгөөд Холбооны нэрийг ашиглах тохиолдолд тухайн судлаач энэ журмын дагуу захиалгыг баталгаажуулах арга хэмжээ авах үүрэгтэй.

4. Судалгааны төвийн эрхлэгч судалгааны ажлыг гүйцэтгэх хэрэгцээ, шаардлага, хүний нөөц, боломжит байдал, Холбооны судалгааны ажлын үндсэн чиглэл зэргийг судалж Салбар эрх зүйн хорооны тэргүүн, эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн хуульч судлаачтай зөвлөлдсөний үндсэн дээр, захиалга хүлээн авах эсэхийг ажлын 3 хоногийн дотор Тамгын газарт танилцуулж шийдвэрлэнэ.

5. Захиалгат судалгааны төслийг гүйцэтгэх шийдвэр гарсан тохиолдолд энэ журмын судалгааны бүтээгдэхүүнийг захиалагчид санал болгож, судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулна.

6. Захиалгат судалгааны ажлыг Тамгын газар холбогдох Салбар эрх зүйн хороонд хариуцуулан цаг хугацаанд бүрэн, чанартай хэрэгжүүлнэ. Тухайн судалгааны ажлын цар хүрээнээс хамааран заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүй бол энэ тухай захиалагчид мэдэгдэж боломжит хугацаа, асуудлын хамрах хүрээг нарийвчлан тохирно.

7. Захиалагчтай өөрөөр тохиролцоогүй бол холбогдох судалгааны ажлыг хэрэгжүүлэхэд энэ журмын Гуравдугаар бүлэгт заасан журмыг баримтална.

8. Бусад байгууллагаас зарласан судалгааг Судалгааны төв, эсхүл Салбар эрх зүйн хороо судалж, судалгааны зохион байгуулалт (баг)-ийг бүрдүүлж, захиалагчийн ажлын даалгавар, шалгуурыг хангах төслийн баримт бичгийг боловсруулан шалгаруулалтад оролцоно.

9. Гадаад улсын төсөл, санаачилгаар зарласан, захиалсан судалгаанд оролцох, хэрэгжүүлэх асуудлыг Тамгын газар судлан, шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ ПРАКТИКТ НЭВТРҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1 дүгээр зүйл. Судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх

1. Судалгааны төв, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо, Салбар эрх зүйн хороо гүйцэтгэсэн судалгааны ажил, төслийн үр дүн, хууль зүйн шинжлэх ухааны эрдмийн болон боловсролын зэрэг горилсон бүтээлийн шинэлэг санал, санаачилгыг бодиттой хэрэгжүүлэх, практикт нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

2. Хууль зүйн шинжлэх ухааны эрдмийн болон боловсролын зэрэг горилсон хуульч болон бусад этгээд өөрийн бүтээлийн үр дүнг практикт нэвтрүүлэхээр Холбоонд хандаж хамтарч ажиллаж болно.

3. Тамгын газар, эсхүл Салбар эрх зүйн хороо шаардлагатай гэж үзвэл Хууль зүйн шинжлэх ухааны эрдмийн болон боловсролын зэрэг горилсон бүтээлийг Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийн дагуу судлаачтай хамтарч хэрэгжүүлж болно.

4. Тамгын газар судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэхээр ирүүлсэн саналыг Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо, Салбар эрх зүйн хороонд хэлэлцүүлэхээр шилжүүлнэ.

5. Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо, Салбар эрх зүйн хорооны гаргасан саналд үндэслэн эрдэмтэн, судлаач, эсхүл судалгааны багтай Тамгын газар судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх гэрээ байгуулж, холбогдох төслийн баримт бичгийг батална.

6. Судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэхэд дараах шалгуурыг хангасан байна:

6.1. бүтээл, түүний үр дүн нь шударга ёс, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, бэхжүүлэхэд чиглэсэн байх;

6.2. бүтээл, түүний үр дүнтэй холбоотой судалгаанд биечлэн оролцсон байх;

6.3. хуульчдын дунд хэлэлцүүлсэн, эсхүл хэлэлцүүлэх боломжтой байх;

6.4. шинэлэг, ач холбогдолтой, бодитой байх;

6.5. хэрэгжүүлэх арга зам, үе шат, хугацаа, үр дүн тодорхой байх;

7. Судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна:

7.1. мэргэшүүлэх сургалтын магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр

7.2. албан бус сургалтын хөтөлбөр;

7.3. эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, семинар, зөвлөгөөн;

7.4. тодорхой санал, зөвлөмж, аргачлал, баримт бичгийн төсөл;

7.5. инновац, ноу-хау-ийн хувьд эерэг үр дүнтэй байх;

7.6. нөлөөллийн арга хэмжээний үр дүн.

8. Судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх арга хэмжээ, үе шат, үр дүн, шаардлагатай зардлыг гэрээ, төслийн баримт бичгээр тодорхойлно.

9. Судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг судлаач өөрөө хариуцаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ

6.1 дүгээр зүйл. Судалгааны ажлын төсөв

1. Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо жил тутам Холбооны санаачилгаар хэрэгжүүлэх судалгааны ажил, зардлын төсөөллийг холбогдох Салбар эрх зүйн хорооны саналд үндэслэн Хуульчдын холбооны Зөвлөлөөр батлуулж, Холбооны төсөвт тусгана.

6.2 дугаар зүйл. Судалгааны ажлын санхүүжилт, зарцуулалт

1. Судалгааны ажлын санхүүжилтийг судалгааны багийн ахлагчийн саналыг үндэслэн Судалгааны төвийн эрхлэгч хянан, Тамгын газрын даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

2. Холбооны санаачилгаар хийж буй судалгааны ажлын санхүүжилтийг холбооны Тамгын газар гаргаж, түүний зарцуулалтад хяналт тавина. Холбогдох хороо нь Судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн, эсхүл захиалсан бол зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

3. Бусад байгууллагаас зарласан, захиалсан судалгааны ажлын гүйцэтгэлийн төлбөр, төсвөөс судалгааны ажилд зайлшгүй шаардагдах зардлыг хасаад судлаач нарын ажлын хөлс, урамшууллаас 20 хувиас бүрдэх хуримтлал үүсгэх зорилгоор Судалгааны төслийн санг байгуулж, тус сангаас бусад судалгааны төслийг гүйцэтгэх, практикт нэвтрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх бөгөөд тухайн санг ашиглах журмыг Зөвлөл тогтооно.

4. Холбооны гишүүн хуульч өөрийн санаачилгаар судалгааны ажлын саналыг олж, баг бүрдүүлэн гүйцэтгэсэн тохиолдолд олгох урамшууллын саналыг Судалгааны төвийн эрхлэгч Тамгын газрын даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

БУСАД

7.1 дүгээр зүйл. Судалгааны ажилд хуульчдын оролцоог дэмжих, урамшуулах

1. Судалгааны төслийн сангаас судалгааны ажил, төслийг гүйцэтгэх болон практикт нэвтрүүлэх ажилд оролцож буй хуульчдад холбогдох журамд заасныг үндэслэн урамшуулал олгоно.

2. Судалгааны ажлыг гүйцэтгэх болон практикт нэвтрүүлэх ажилд оролцож буй хуульчдад татварын хөнгөлөлт үзүүлэх, практик сургалтаар олгох кредитийг тооцож болно.

3. Судалгааны ажлыг гүйцэтгэх болон практикт нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд практикийн туршилт хийх, бодитойгоор хэрэгжүүлэхэд оролцож буй хуульчийн буруутай ажиллагаанаас үүдэн Холбоонд, эсхүл бусад этгээдийн хувьд хохирол учруулсан бол холбогдох хуульч учруулсан хохирлыг арилгах бүх арга хэмжээг авна. Хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой асуудалд холбогдох хууль тогтоомжийн дагуу буруутай этгээд нь хариуцлага хүлээнэ.

7.2 дугаар зүйл. Журам хүчин төгөлдөр болох

1. Энэ журмыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.